

Ректорын 2004 оны 5-р сарын 19-ны
117. тоот тушаалын хавсралт

81

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Ёслолын хувцасны загвар, хэрэглэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Ёслолын хувцас нь ШУТИС-ийн нэр төрийн бэлэгдэл төдийгүй зэрэг, цол олгох ёслолын ажиллагааны сүр хүчийг илэрхийлнэ.

Хоёр. Ёслолын хувцасны хэв загвар

2.1. Ёслолын хувцсыг дараах байдлаар ангилна. Үүнд:

Хүндэт докторын ёслолын хувцас

Докторын ёслолын хувцас

Хүндэт магистрын ёслолын хувцас

Магистрын ёслолын хувцас

Бакалаврын ёслолын хувцас

2.2. Хувцасны бүрэлдэхүүн

Хүндэт докторын хувцас нь малгай, өмсгөл хоёроос бүрдэнэ.

Доктор, магистрын хувцас нь өмсгөл, нэмрөг, малгай гурваас бүрдэнэ.

Бакалаврын хувцас нь өмсгөл, малгай хоёроос бүрдэнэ.

2.3. Хувцасны гадаад байдлын тодорхойлолт:

2.3.1. Хүндэт докторын хувцас. Хувцас нь дэлхийн улс орнуудын их сургуулийн ёслолын хувцасны нийтлэг жишигт үндэслэсэн, монгол үндэсний хувцасны зарим онцлог болон ШУТИС-ийн өнгөний бэлэгдлийг тусгасан байна. /Зургийг 1-р хавсралаар үзүүлэв/

Өмсгөл нь: хөх өнгийн торгоор хийгдэх бөгөөд сул чөлөөтэй хэлбэртэй, энгэр нь уулзсан зөрлөгтэй, ханцуй нь үзүүрээрээ өргөссөн хэлбэртэй, давхарлагатай, энгэртээ гурван ширхэг зангидал товч, шилбэтэй, энгэр болон ханцууны үзүүрээр 2.0 см-ийн өргөнтэй шар тортон эмжээртэй.

Малгай нь: дэлхийн улс орны их сургуулиудын ёслолын хувцасны нийтлэг жишигээр хийгдсэн, монгол үндэсний хувцасны шинжийг агуулсан улаан залаатай, шар тортог 2.0 см-ийн өргөнтэй эмжсэн, малгайны дээд хүрээгээр нарийн шар эмжээртэй, 4 өнцөгт нь зангидал суурь бүхий цацагтай байна.

Дагалдах хэрэглэл: Малгай болон өмсгөл зориулалтын уут дагалдах бөгөөд эдгээр дээр ШУТИС-ийн эмблемийг хатгамлаар гүйцэтгэсэн байна.

2.3.2. Докторын хувцас. Хувцас нь дэлхийн улс орны их сургуулиудын ёслолын хувцасны нийтлэг жишигт үндэслэсэн, ШУТИС-ийн өнгөний бэлэгдлийг тусгасан байна. /Зургийг 2-р хавсралтаар үзүүлэв/

Өмсгөл нь хар өнгийн сатин буюу атлас материалыар хийгдэх бөгөөд сул чөлөөтэй хэлбэртэй, энгэр нь уулзсан зөрлөгтэй, цахилгаан товчоор товчлогдсон, энгэр, арын дээд хэсэгт хөндлөн оруулгатай, ар дээр 7, энгэрт 6 нугалаатай, ханцуй нь үзүүрээр өргөссөн хэлбэртэй. Ханцуун үзүүр алтан шар өнгийн материалыар 5.0 см, 1.0 см-ийн өргөнтэй эмжигдсэн байна.

Нэмрөг нь энгэр рүүгээ хошуу, ар руугаа дөрвөлжилсөн хошуу хэлбэртэй, өмсгөлтэй ижил материалыар хийгдсэн, 5.0 см, 7.0 см-ийн өргөн алтан шар өнгийн даавуугаар эмжигдсэн, доторлогдсон байна.

Малгай нь дэлхийн улс орны их сургуулиудын ёслолын хувцасны нийтлэг жишигээр хийгдсэн, малгайны голоос гарсан зангидал суурь бүхий шар өнгийн цацган унжлагатай байна.

2.3.3. Хүндэт магистр, Магистрын хувцас Хувцас нь дэлхийн улс орны их сургуулиудын ёслолын хувцасны нийтлэг жишигт үндэслэлсэн, ШУТИС-ийн энгэний бэлэгдэл, мэргэжлийн онцлогийг тусгасан байна. /Зургийг 3-р хавсралтаар үзүүлэв/

Өмсгөл нь хар хөх өнгийн сатин буюу атлас материалыаар хийгдэх бөгөөд сүл чөлөөтэй хэлбэртэй, энгэр нь уулзсан зөрлөгтэй, цахилгаан товчоор төвлөгдсон, энгэр арын дээд хэсэг оруулгатай, ар дээр 7, энгэрт 6 нугалаатай, ханцуйны их биетэй залгагдах хэсэгт хуниас гаргасан, ханцуйны үзүүрийг уртасган, хэлбэр гаргасан байна.

Нөмрөг нь энгэр, ар руугаа хошуу хэлбэртэй, өмсгөлтэй ижил өнгийн материалыаар хийгдсэн, 3.0 см-ийн өргөнтэй шар өнгийн материалыаар эмжигдсэн байна. Мэргэжлийн онцлогийг тусгасан өнгийн торгомсог материалыаар доторлогдсон байна. Мэргэжлийн онцлогийг тусгасан материалын өнгө нь:

- инженерийн ухаан – цэнхэр
- байгалийн ухаан – гүн ногоон
- арт, дизайн – цагаан
- эдийн засаг, менежмент – ягаан
- хүмүүнлэгийн ухаан – оюу ногоон өнгөтэй байна.

Малгай нь дэлхийн улс орны их сургуулиудын ёслолын хувцасны нийтлэг шишгээр хийгдсэн, малгайны голоос гарсан зангидал суурь бүхий шар өнгийн цаган унжлагатай байна.

2.3.4. Бакалаврын хувцас. Магистрын хувцасны адил хийц загвартай боловч нөмрөг өмсөхгүй. /Зургийг 4-р хавсралтаар үзүүлэв/

Өмсгөл нь хар хөх өнгийн сатин буюу атлас материалыаар хийгдэх бөгөөд сүл чөлөөтэй хэлбэртэй, энгэр нь уулзсан зөрлөгтэй, цахилгаан товчоор төвлөгдсон, энгэр арын дээд хэсэгт хөндлөн оруулгатай, ар дээр 7, энгэрт 6 нугалаатай, ханцуйны их биетэй залгагдах хэсэгт хуниас гаргасан, ханцуйны үзүүрт уртасган хэлбэр гаргасан байна.

Малгай нь дэлхийн улс орны их сургуулиудын ёслолын хувцасны нийтлэг шишгээр хийгдсэн, малгайны голоос гарсан зангидал суурь бүхий шар өнгийн цаган унжлагатай байна.

Гурав. Ёслолын хувцсыг өмсөх журам

3.1. Ёслолын хувцсыг зэрэг, цол олгох арга хэмжээний үеэр өмссөнө.

3.2. Төгсөгчид нь өмсгөлдөө гүн хүндэтгэлтэй хандаж, ёслолын экиллагааны туршид дэг жаягийн дагуу өмсөж хэрэглэнэ.

3.3. Ёслолын хувцсыг өмсөхдөө дараах дэг жаягийг баримтлана. Үүнд:

Хүндэт доктор – Докторын өмсгөлийг цол гардуулахаас өмнө өмссөн байх бөгөөд цол гардуулсны дараа ШУТИС-ийн хүндэтгэлийн одонг зүүж, малгайг өмсгөнө.

Доктор, Магистр - Өмсгөл, малгайг бүрэн өмссөн байна. Нөмрөгийг доктор, магистрын зэргийн диплом авсны дараа өмссөнө. Цацгийг цол, зэрэг гардан авахаас өмнө малгайны баруун тал руу нь унжуулсан байдлаар өмсөх бөгөөд цол, зэрэг гардан авсны дараа зүүн тал руу нь байрлуулах бөгөөд энэ нь доктор, магистрын зэрэгтэй мэргэжилтэн болсныг илтгэнэ.

Бакалавр - Ёслолын ажиллагааны эхэнд зөвхөн өмсгөлийг өмссөн байх бөгөөд диплом, энгэрийн тэмдгийг гардан авсны дараа малгайг өмссөнө. Малгайны цацаг зүүн тал руугаа унжсан байна.

ШУТИС-ийн ёслолын хувцасны загвар,
хэрэглэх журмын 1 дүгээр хавсралт

Хүндэт докторын хувцас



Xundet Doktoryn Huvtas

ШУТИС-ийн ёслолын хувцасны загвар,
хэрэглэх журмын 2 дүгээр хавсралт

Докторын хувцас



ШУТИС-ийн ёслолын хувцасны загвар,
хэрэглэх журмын 3 дүгээр хавсралт

25

Магистрын хувцас




and TIG - 22, general assembly, and the
TIG - 22, general assembly

general assembly



general assembly



general assembly

general assembly